



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/07

Сүмбэр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.12, 10.2.16 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын хавсралт “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн 4.5.4, 6.1.1, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны “Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан “Эрүүл аюулгүй- Цэвэр орчин” бүрдүүлэх арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгаврын 1.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 сарын 02-ны өдрийн хуралдааны “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолын 05 дугаар хавсралт “Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 2.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зөв дадал, эерэг өөрчлөлт, ногоон ирээдүй” аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиуд, Политехникийн коллежийг хамруулан зохион байгуулах “Эко өртөө” нөлөөллийн арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Эко өртөө арга хэмжээг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, тайлагнахыг ахлах мэргэжилтэн (Б.Гандулам)-д үүрэг болгосугай.

3. Эко өртөө арга хэмжээнд зарцуулах 1,333,000.0 (нэг сая гурван зуун гучин гурван мянга) төгрөгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.МӨНХ-ЭРДЭНЭ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/аг

Сүмбэр сум

Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.6, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Цагаан сарын баярыг тохиолдуулан байгууллагын харъяа ахмад настанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулах арга хэмжээний зардалд 480000 төгрөг зарцуулсугай.

2. Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх зардал 480000 (дөрвөн зуун наян мянга) төгрөгийн байгууллагын Ахмадын сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.МӨНХ-ЭРДЭНЭ

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 40/ дүгээр тушаалын 1-р хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Орон тоо
1	2	3	4
1	Газрын дарга	T3-4	1
2	Байгаль орчны улсын хяналтын байцаагч	T3-7	1
3	Байгаль орчны бодлогын хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-8	1
4	Аялал жуулчлал тусгай хамгаалалттай газар нутаг, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
5	Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
6	Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн гамшиг, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
7	Ой, цөлжилт, биологийн олон янз байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
8	Сүмбэр сумын байгаль хамгаалагч	T3-9	1
9	Нягтлан бодогч	TY-8	1
10	Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав	TY-5	1
11	Улсын тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан харуул хамгаалалтын ахлагч	TY-3	1
12	Жолооч	TY-3	1
13	Үйлчлэгч	TY-1	1
	Нийт		13



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 1/03

Сүмбэр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Аймгийн 2022 оны төсвийг батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 02 -ны өдрийн 11 дугаар тогтоолын 05 дугаар хавсралтын 2.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Ойн газартай хамтран JCI Монгол төрийн бус байгууллагын “Их хүрээ” салбараас тус орон нутгийн ЕБС-ийн сурагчдад “Ногоон ирээдүй” сэдэвт багц сургалтыг зохион байгуулах болсон тул сургагч багш нарыг орон нутагт байршуулахтай холбогдон гарах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар баталсан 140 000 (нэг зуун дөчин мянга)-н төгрөгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтын үйл ажиллагаа болон сургагч багш нарыг байршуулахтай холбогдох ажлыг хариуцан зохион байгуулж, сургалтын үр дүнг танилцуулахыг Ой, цөлжилт, биологийн олон янз байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн (М.Номинзул)-д даалгасугай.

ДАРГА



Д.МОНХ-ЭРДЭНЭ

D:/bichig hereg/ Tushaal.doc/

4273010028



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/04

Сүмбэр сум

Хариуцлагатай жижүүр ажиллуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 17 дугаар жарны үзэсгэлэнт болгогч хэмээх туулай жилийн сар шинийн баярын өдрүүдэд ажиллах байгууллагын хариуцлагатай жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан хуваарийн дагуу жижүүрийг хариуцлагатай хийж гүйцэтгэхийг албан хаагчдад, тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах мэрэгжилтэн (Б.Гандулам)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХ-ЭРДЭНЭ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/05

Сүмбэр сум

Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ
хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журмын 2.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тус байгууллагын албан байр өөрчлөгдөн нэг байранд хэд хэдэн байгууллага төвлөрөн үйл ажиллагаа явуулах болсонтой холбогдуулан гамшгийн эрсдэлийн нөхцөл байдал өөрчлөгдсөн тул шинэ объектод эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийлгэхээр ажлын хэсгийг хамт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын төлөөллийг хамруулан дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА
ГИШҮҮД

Б.Гандулам (Ахлах мэргэжилтэн)
М.Номинзул (Ой, цөлжилт, биологийн олон янз байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн)
Ц.Цэрэнчимэд (Нягтлан бодогч)
С.Саранчимэг (Бичиг хэрэг, архивын эрхлэгч нярав)
Н.Солонго (Зөвшилцсөнөөр) (Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргааны мэргэжилтэн)
А.Оч-эрдэнэ (Зөвшилцсөнөөр)
(Сум дундын ойн ангийн жолооч)
Г.Энхжин (Зөвшилцсөнөөр)
(Насан туршийн боловсролын төвийн багш)
Н.Маралгуа (Хүрээлэн буй орчин, байгалийн гамшиг, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн)

НАРИЙН БИЧИГ

2.Уг гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг 2023 оны 03 дугаар сарын 15-ны дотор хийж, ажлын үр дүн мэдээг танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Б.Гандулам)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХ-ЭРДЭНЭ

D:/bichig hereg/ Tushaal.doc/

4023010030



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/05

Сүмбэр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Аймгийн 2023 оны төсвийг батлах тухай" 2022 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 11 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

2. Нэн ховор, ховор амьтныг хамгаалах хүрээнд Чойрын богд уулан дахь аргаль хонийг өвс тэжээлийн хомсдолд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах биотехникийн арга хэмжээний төсвийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээний зардалд зарцуулагдах 690 600.0 /зургаан зуун ерэн мянга зургаан зуун/ төгрөгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д.МӨНХ-ЭРДЭНЭ



D:/bichig hereg/ Tushaal.doc/

4223010033